



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/414

Мандалговь

Аймгийн "Шилдэг санхүүч, эдийн засагч"-ийг
шалгаруулж, урамшуулах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.4, аймгийн Засаг даргын 2017 оны А/407 дугаар захирамжаар батлагдсан "Шилдэг төрийн албан хаагчийг шалгаруулж, урамшуулах журам"-ын 4.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 14 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2019 оны аймгийн "Шилдэг санхүүч, эдийн засагч"-аар Дундговь аймгийн Ерөнхий санхүүч Сумъяа овогтой Энхжаргал, Нийгмийн даатгалын хэлтсийн санхүү бүртгэлийн тасгийн дарга Равжих овогтой Нэргүй нарыг шалгаруулж тус бүр өргөмжлөл, 1000000 төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

Хоёр. Шилдэг санхүүч, эдийн засагчийн урамшууллын зардлыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Гурав. Шагналын зардалд шаардагдах 2.108.000 (Хоёр сая нэг зуун найман мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488191173

Аймгийн Засаг даргын 2019 оны
12 дугаар сарын 03-ны өдрийн 44 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



ШИЛДЭГ САНХҮҮЧ, ЭДИЙН ЗАСАГЧ УРАМШУУЛАХ,
УРАМШУУЛЛЫН ЗАРДАЛ

№	Зардлын утга	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Урамшуулал	2	1.000.000	2.000.000
2	Өргөмжлөл	2	48.000	96.000
3	Батламж	2	6.000	12.000
	ДҮН			2.108.000